



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 05 өдөр

Дугаар A/490

Улаанбаатар хот

Г Эмнэлзүйн заавар батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Ясны хугарлын үед үзүүлэх яаралтай тусlamжийн эмнэлзүйн заавар"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал наарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газар (М.Баттүвшин), Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ




Эрүүл мэндийн сайдын

2018 оны 12 сарын 23 ны өдрийн

дугаар тушаалын хавсралт

4/490

ЯСНЫ ХУГАРЛЫН ҮЕД ҮЗҮҮЛЭХ ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЭМНЭЛЗҮЙН ЗААВАР



1. Товчилсон үгийн жагсаалт:

- ЭМЯ: Эрүүл мэндийн яам,
- ДЭМБ: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
- ГССҮТ: Гэмтэл согог судлалын үндэсний төв

2. Оршил:

Гэмтлийн шалтгаан эмгэг жам, оношилгоо эмчилгээ, гарах хүндрэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх аргыг судалдаг **Traumatology** буюу гэмтэл судлалын ухаан нь: Trauma буюу гэмтэл, *logus* буюу сургаал гэсэн Грек үгнээс гаралтай эмнэлзүйн анагаах ухаан юм.

Гэмтэл, согог судлал нь XX зууны эхэн үеэс тулгуур хөдөлгөөний эрхтэний мэс засал хэлбэрээр хөгжсөн. Тулгуур хөдөлгөөний эрхтэний согогийг засах төдийгөөр хязгаарлагдахгүй уул согогийг үүсгэхэд хүргэсэн шалтгааныг эхийн хэвлийд байх үеэс нь судалж, оношилж, эмчилж, болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч өхөлсэн.

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА.

1.1. Онош, хам шинж

ТОДОРХОЙЛОЛТ.

Хугарал /Fracture/: Ясны бөх бат чанараас давсан гадны хүчний үйлчлэлээр ясны бүрэн бүтэн байдал алдагдаж орчны зөөлөн эд хамт гэмтэж үйл ажиллагаа нь сарнихыг хэлнэ.

1.2 Хэрэглэгчид:

- Энэхүү зааврыг төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэг, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн яаралтай тусlamжийн их эмч, бага эмч, гэмтэл согогийн эмч, мэргэшсэн эмч нарын баг үйл ажиллагаандaa хэрэглэнэ.
- Бүх шатны эмнэлгийн амбулатор, поликлиникийн гэмтэл согог ба мэс заслын их, бага эмч, ерөнхий мэргэжлийн эмч нар үйл ажиллагаандaa хэрэглэнэ.

1.3 Зааврын зорилго, зорилт:

1.3.1 Зорилго:

- Ясны хугарлын үед үзүүлэх эмнэлгийн яаралтай тусlamжийн чанар, хүртээмжийг сайжруулах,

1.3.2 Зорилт:

- Ясны хугарлын үед үзүүлэх эмнэлгийн яаралтай тусlamжийг цаг алдалгүй авах,
- Оношлох, зөв тээвэрлэх, хугарлаас үүдэн гарах сөрөг үр дүн, эмгэг, хүндэрлээс урьдчилан сэргийлэх.

1.4 Тархвар зүйн мэдээлэл:

ДЭМБ-ын тайлан мэдээгээр нийт өвчлөлийн аравны нэгийг осол гэмтлийн өвчлөл эзэлж байгаа бөгөөд жил бүр дэлхий даяар 5,2 сая гаруй хүн осол гэмтлийн улмаас амь нас алдаж байгаа бөгөөд 2020 онд осол гэмтлийн улмаас нас барах хүний тоо 8,4 саяд хүрэх магадлалтай байна.

Дэлхийн улс орнуудад жил бүр 1 тэрбум гаруй хүн хөдөлмөрийн чадвараа түр алддаг бөгөөд тэдгээрийн ихэнх нь бага дунд орлоготой улс орнуудад бүртгэгдсэн байна. Дэлхийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүртгэл мэдээлэл дутагдалтай байдаг хэдий ч тэдгээрийн 1/4 нь санамсаргүй осол гэмтлийн (зам тээврийн осол, уналт, түлэгдэлт, хүчирхийллээс үүссэн) улмаас нуруу нугасны саажилт, гэмтсэн эрхтнийг авахуулах (ампутаци), сэтгэлзүйн гэмтэл, сохор, дүлий гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй болдог байна.

Монгол улсын хүн амын өрүүл мэндийн статистик мэдээгээр осол гэмтлийн өвчлөл нь хүн амын өвчлөлийн 5 дугаарт орж байна. Осол гэмтэлд эрэгтэйчүүд илүү өртдөг бөгөөд сүүлийн 5 жилийн үзүүлэлтээс харахад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1,8 дахин их өртсөн байна. 2012-2016 онд бүртгэгдсэн осол гэмтлийн өвчлөлийн голч нас 28 байсан ба 20-34 насны хүмүүс их өртөж байна. Энэ нь хөдөлмөрийн насны залуучууд осол гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа түр болон удаан хугацаагаар алдаж, хөгжлийн бэрхшээлтэй болох цаашлаад улс орны эдийн засаг, хөгжил, дэвшилд сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.

Ясны хугарал үүсэх тэргүүлэх шалтгаан нь "Уналт (W00-W19)"байдагбайна. Дэлхий дахинд жил бүр ойролцоогоор 37,3 сая хүн унаж гэмтсэний улмаас эмнэлгийн тусlamж үйлчилгээ авдаг ба 424 мянган хүн нь нас барж, 80% нь бага дунд орлоготой улс оронд бүртгэгджээ. Жил бүр 64-өөс дээш настай хүмүүсийн 28-35%, 70-аас дээш настай хүмүүсийн 32-42% нь унаж гэмтдэг ба унаж гэмтсэн байршилаар нь ихэнх хувь нь гудамж зам талбай болон олон нийтийн газар /56%, 26% нь тэгш гадаргуу дээр, 6% нь шат, ванн шүршүүрт орж байх үедээ гэмдэг байна. Номхон далайн баруун эргийн бүс нутагт 4.7 сая хүн унаж гэмтсэнээс 142 мянган хүн нас бардаг бөгөөд өдөрт 5-14 насны 130 хүүхэд унаж гэмтсэний улмаас нас барж байна.

Монгол улсад жил бүр унаж гэмтэх шалтгаан нь осол гэмтлийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болдог бөгөөд осол гэмтэлд өртсөн 10 хүн тутмын 3 нь унаж гэмтсэний улмаас эмнэлгийн тусlamж үйлчилгээ авсан ба тэдгээрийн 56.6%-ийг эрэгтэйчүүд, 43.4%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

2012-2017 онд нийт 240056 хүн унаж гэмтсэн шалтгаанаар бүртгэгдсэн бөгөөд дундаж нас 28, хамгийн бага нь 1 хүртэлх насны хүүхэд, хамгийн өндөр настай нь 112-той үйлчлүүлэгч байсан байна.

Насны бүлгээр авч үзэхэд нас ахих тусам унаж гэмтсэн тохиолдлын түвшин 10000 хүн амд ихсэж байна. 50-аас дээш насанд тохиолдлын түвшин огцом ихсэж байгаа бөгөөд 70-аас дээш насанд хамгийн их буюу 10000 хүн амд 224-266 байна.

Монгол улсад 2012-2017 онд осол, гэмтлийн улмаас тусламж, үйлчилгээ авсан хүмүүсийн гэмтлийн оношийг өвчний олон улсын ангилал 10-ын дагуу үзүүлбэл эхний байруудад:

- Толгойн гэмтэл – 28.8%
- Тохой ба шууны гэмтэл – 11.3%
- Өвдөг шилбэний гэмтэл - 11.1%
- Бугуй ба сарвууны гэмтэл – 10.8%
- Шагай ба тавхайн гэмтэл – 9.0%
- Мөр ба бугалганы гэмтэл - 5.1%
- Түнх ба гуя орчмын гэмтэл – 3.7% эзэлж байна. Үүнээс харахад нийт гэмтсэн хүмүүсийн ихэнх нь мөчдийн гэмтэл (51%) авсан байна.

Гэмтлийн шалтгаанаар нь авч үзвэл унаж гэмтсэн хүмүүсийн 69.1% (тэр дундаа дээд доод мөчдийн хугарал 41.5%-ийг дээд, доод мөчдийн хугарал), зам тээврийн осолд өртөж гэмтсэн хүмүүсийн 43.5%, хүчирхийлийн улмаас гэмтсэн хүмүүсийн 15.4%, нь мөчдийн гэмтэл авсан байна.

1.5 Үндсэн ойлголт: Ясны бат бөх чанараас давсан гадны хүчний үйлчлэлээр ясны бүрэн бүтэн байдал алдагдаж орчны нь зөвлөн эд хамт гэмтэхийг хугарал гэнэ. Ясны үрэвсэл, хавдар, хөндийн улмаас, өчүүхэн бага хүчний үйлчлэлд яс хугарахыг эмгэг хугарал гэнэ. Бүх хугарлын дотор дээд, доод мөчдийн хугарал 65-70% тохиолдоно.

Хугарал нь ил ба далд гэсэн хоёр хэлбэртэй. Ил хугарлын үед хугарлын түвшинд шарх үүсч, хугарлын хэсэгтэй холбоотой байх тул нянгаар халдвартлагдах магадлалтай гэж үздэг. Яс гүйцэд хугарахаас гадна цуурсан, эсвэл аль нэг хэсэг бүтэн үлдсэн байж болно.

Хүүхдийн ясны шар хальс зузаан байдгаас яс нь хугарсан ч шар хальс нь бүтэн үлдэх тул оношлоход бэрхшээлтэй байдаг. Ясанд бэхлэгдсэн булчингуудын үйлчлэлээр хугарлаар хөндлөн, өнцөглөсөн болон уртааш, эргэлтэй зөрүү үүсдэг.

Үений ойролцоо хугарал үений хөндийрүү холбоотой болохыг үе доторх хугарал гэнэ.

Чөмөгт ясны хугарал нь голчлон гандан хэсгээр /ясны дунд хэсэг/ хугарч хэв шинжит зөрүүг үүсгэх нь элбэг. Жишээлбэл: Дунд чөмөгний дээд, дунд хэсгээр хугарахад төвийн үзүүр нь гадагш овойж, захын хэсэг нь дотогш дээш зөрдөг. Үений ойролцоо хугарал, мултрапл хавсрлан тохиолдож болно.

1.5.1 Эрсдэлт хүчин зүйл:

- Ясны эдийн архаг эмгэг өвчлөл, ясны хавдар, сурьеэ, тэмбүү, төрөлхийн ясны эмгэг, архаг идээт үрэвсэл, чихрийн шижингийн хүнд хэлбэр, ясны сийрэгжилт, бусад эрхтэн системийн архаг үрэвсэлт өвчин эмгэг, насжилт.
- Сэтгэцийн эмгэг өөрчлөлт, архаг архичин
- Хотжилт, авто зам

1.5.2 Өвчний тавилан: Үйлчлүүлэгчийн биеийн өөрхий байдал, нас, хүйс, хугарлын шалтгаан, хугарлын хэлбэр, яаралтай тусламж үзүүлсэн цаг хугацаа, байдал, тээвэрлэлт, дараагийн шатны эмнэлгийн оношилгоо, эмчилгээнээс шууд хамаарна.

БҮЛЭГ 2. ЯСНЫ ХУГАРЛЫН ИЛРҮҮЛЭГОНОШИЛГОО (АЛГОРИТМ)

2.1. Өвчний олон улсын 10-р ангиал, өвчний код (өвчний олон улсын 10-р ангиал).

| Оношийн ангиал ICD-10 | Өвчний ангиал |
|----------------------------------|---|
| S32.4 | Түнхний тогооны хугарал |
| S32.4 | Умдаг ясны хугарал |
| S32.8 | Суудлын ясны, аарцагийн хугарал |
| S42.0 | Эгэмний хугарал |
| S42.1 | Далны хугарал |
| S42.2 | Атгаал ясны дээд хэсгийн хугарал |
| S42.3 | Атгаал ясны гандан хэсгийн хугарал |
| S42.4 | Атгаал ясны доод хэсгийн хугарал |
| S52.0 | Богтос ясны дээд хэсгийн хугарал |
| S52.1 | Шуу ясны дээд хэсгийн хугарал |
| S52.2 | Богтос ясны гандан хэсгийн хугарал |
| S52.3 | Шуу ясны гандан хэсгийн хугарал |
| S52.4 | Шуу, богтос ясны гандан хэсгийн хавсарсан хугарал |
| S52.5 | Шуу ясны доод хэсгийн хугарал |
| S62.3 | Шивнүүр ясны хугарал |
| S62.2 | Гарын I шивнүүрийн хугарал |
| S62.5 | Гарын эрхий хурууны хугарал |
| S62.6 | Гарын бусад хурууны хугарал |
| S62.7 | Гарын хуруудын олон хугарал |
| S72.0 | Дунд чөмөгний хүзүүны хугарал |
| S72.1 | Дунд чөмөгний төвгөр дайрсан хурагал |
| S72.2 | Дунд чөмөгний төвгөрийн доогуурхи хугарал |
| S72.3 | Дунд чөмөгний гандан хэсгийн хугарал |
| S82.0 | Тойгны хугарал |
| S82.1 | Шаантны дээд хэсгийн хугарал |
| S72.4 | Дунд чөмөгний доод хэсгийн хугарал |
| S82.2 | Шаантны гандан хэсгийн хугарал |
| S82.4 | Тахилзуур ясны хугарал |
| S82.5 | Дотор хавчаар ясны хугарал |
| S82.6 | Гадна хавчаар ясны хугагал |
| S92.0 | Өсгийн ясны хугарал |
| S92.1 | Шагай ясны хугарал |
| S92.2 | Хөлийн жижиг ясны хугарал |
| S92.3 | Хөлийн шивнүүрийн хугарал |
| S92.4 | Хөлийн эрхий хурууны хугарал |
| S92.5 | Хөлийн бусад хурууны хугарал |

2.2 Үйлдлийн олон улсын 9-р ангилаал

| Үйлдлийн ангилаал ICD-9 | Үйлдлийн ангилаал |
|----------------------------|--|
| 89. | Ярилцлага, дүгнэлт, зөвлөгөө ба шинжилгээ |
| 89.7 | Биеийн өрөнхий үзлэг шинжилгээ |
| 79 | Хугарал, мултран засах |
| 93.5 | Шархыг хөдөлгөөнгүй болгох, дарж боох болон цэгцлэх бусад арга. |
| 93.51 | Гөлөтгөнөн боолт хийх |
| 93.52 | Хүзүүнд тулгуур үүсгэх |
| 93.53 | Бусад төрлийн чиг тавих |
| 93.54 | Чиг тавих |
| 93.56 | Даралттай боолт хийх |
| 93.57 | Бусад төрлийн даралттай боолт хийх |
| 93.58 | Даралттай өмд өмсгэх |
| 93.59 | Шархыг хөдөлгөөнгүй болгох, дарж боох болон цэгцлэх бусад арга |
| 93.6 | Ясны эмгэгийг эвээр, гараар засах эмчилгээ |
| 93.64 | Адил даралтат хүч хэрэглэж ясны эмгэгийг гар аргаар засах, эвд оруулах |
| 93.65 | Шууд бус хүчээр ясны эмгэгийг гар аргаар засах, эвд оруулах |
| 93.93 | Сэхээн амьдроулах механик бус аргууд |
| 96.59 | Шарх угаах бусад арга |
| 97.11 | Дээд мөчдөд чиг тавих |
| 97.12 | Доод мөчдөд чиг тавих |
| 99.63 | Зүрхэнд шууд бус иллэг хийх |
| 99.84 | Тусгаарлал |

2.3 Хугарал, эмнэл зүйн шинж:

2.3.1 Атгаал ясны хугарал.

Шалтгаан.

- Атгаалын дээд булуу, чөмөгт хэсэг, доод булуу атгаалын толгой, хүзүү нь мөрний үеэр гадна талд цохих, тохой сарвуугаар тулж унахад хугарна. Атгаалын хүзүү дайрсан хугарал нь шууд бус үйлчлэлээр үүснэ.

Шинж тэмдэг.

- Хавдах, өвдөх, хөдөлгөөн хязгаарлагдсан, мөч бодиноссон, хэлбэр алдагдсан, хугарлын үзүүр гарч тэмтрэгдэх шинж илэрнэ.
- Мөчний тэнхлэг өөрчлөгдөх, хавдах, хавагнах, өвдөх шинж тэмдэг гарч хугарлын чимээ тэмтрэхэд мэдэгдэнэ. Орчиндоо хавагнаж, өвдөх, тохойн үеэр нугалах, тэнийлгэхэд өвдөлт нэмэгдэнэ.

Хүндрэл.

- Атгаалын доод хэсгийн хугарлын уед мэдрэл гэмтэх аюултай, бага насы хүүхдэд тохиолдоно. Энэ уед сарвуугаар унжих, хуруудыг тэнийлгэх идэвхитэй хөдөлгөөн алдагдана.

2.3.2 Шуу, багтос ясны хугарал.

Шалтгаан.

- Хугарал нь ихэвчлэн авто осол, ахуйн нөхцөлд, спортын уралдаан тэмцээний үед тохиолдоно. Шуу, багтосны аль нэг хугарахад уртааш зөрөхгүй харин хөндлөнгийн болон эргэлтийн зөрүү үүснэ. Шуу багтос ясны дээд булуу, чөмөтг хэсэг, доод булуу, чөмөтг хэсгийн дагнасан ба хавсарсан, чөмөтг хэсгийн дээд, дунд, доод хугарал элбэг тохиолдоно.

Шинж тэмдэг.

- Хаван хавдартай, өвчин эмзэглэлтэй, мөчний чиг өөрчлөгдсөн, ясны хавиралдах чимээ мэдрэгдэх, хугаралын үзүүр тэмтрэгдэх, тохой, бугуйн үений хөдөлгөөн хязгаарлагдах, тэнхлэгээрээ гадагш, дотогш эргэх өөрчлөлтүүд, шууны мэдрэл дарагдах, мэдрэл тэжээл дутмагшлын шинж илэрнэ.

Хэлбэр.

- Багтос яс чөмөтг хэсгээр хугарч, шуу ясны толгой урагш юмуу, арагш мултрахыг "Монтдеж"-ийн хугарал мултран,
- Шуу яс чөмөтг хэсгээр хугарч багтосны доод үзүүр мултрахыг "Галлиец"-ийн хугарал, мултран гэнэ.

Хүндрэл.

- Хос ястай, олон давхар булчинтай тул хугарлыг оношлох, эмчлэхэд хүндрэл гардаг.

2.3.3 Шууны хугарамтгай хэсгийн хугарал.

Шалтгаан.

- Шуу ясны үений доод гадаргуугаас дээш 2 см-д хугарахыг хэлнэ. Гарын алгаар юмуу ар хэсгээр дарж унах, авто ослын үед тохиолдоно. Ялангуяа өвлийн улиралд эмэгтэй хүмүүст илүү их тохиолдоно.

Хэлбэр.

- Гарын алгаар дарж унахад хугарлын төвийн үзүүр арагш, доошоо зөрөхийг "Коллес"-ийн, алганы ар хэсгээр дарж унахад хугарлын төвийн үзүүр урагш доошоо чиглэлд зөрөхийг "Смит"-ийн хугарал гэнэ.

Шинж тэмдэг.

- Тэмтрэхэд бугуйн үеэр хавантай хөдөлгөөн хязгаарлагдсан, хэлбэр дүрс өөрчлөгдөж, урагш юмуу арагш цүлхийсэн, гарын сарвуу чинэрсэн, хугарлын үзүүр мэдрэгдэнэ.

2.3.4 Сарвуу ясны хугарал.

Шалтгаан.

- Шууд үйлчлэлийн хүчээр ихэвчлэн хугардаг. цусан судал ихтэй тул бусад хүндрэлээс сэргийлж ажиллах шаардлагатай.

Хүндрэл

- Сарвууны ил шархны үед хурууны нугалах, тэнийлгэх хөдөлгөөний үед шөрмөс гэмтэнэ. Эдгээр гэмтлүүдийн үед ихэнх үйлчлүүлэгчид өөрсдөө хугарлыг зассанаар мэдрэл судал ба судас гэмтэх аюултай байдаг тул эмнэлгийн байгууллагад яаралтай үзүүлэхийг зөвлөх хэрэгтэй.

2.3.5 Аарцагны хугарал.

Шалтгаан.

- Аарцаг яс нь 2 сүүжний яс, ууц ахар сүүлний яснаас тогтсон хөндий цагирагт эрхтэн бөгөөд умай, үтрээ, давсаг, шээлгүүр, үрийн суваг зэрэг эрхтэнүүд байрлана. Өндрөөс унах, аарцагны ар өвөр талаас хавчигдаж дарагдаж, шахагдах, шууд цохиулах зэргээс хугарна. Ялангуяа газар шороо, барилга байшинд дарагдах, авто ослын үед ихэвчлэн тохиолдоно.

Хүндрэл.

- Аарцаг ясны хугарлын үед дотор эрхтэний гэмтлээс гадна цус алдалт, өвдөлтийн шокоор хүндэрч өвчтний амь насанд аюул тулгарах эрсдэл их гардаг.

Хэлбэр.

- Зах хязгаарын
- Аарцагны цагираг тасраагүй
- Аарцагны цагираг тасарсан
- Сүүжний тогооны
- Хавсарсан хэлбэртэй байж болно.

Шинж тэмдэг.

- Өвдөлт ихтэй, артерийн даралт буурах, судасны лугшилт олшрох ,ерөнхий шинжээс гадна гэмтсэн талын доод мөч гадагш эргэх, мөч богиносох, өвдөгний үеэр нугалах боловч хөлөө дээшээ өргөж чадахгүй байх /Өсгий наалдах/, 2 талын ташаан дэлбээний гаднаас дотогш шахахад аарцагны гүнд өвдөлт ихсэх /Вернель/,ташаан дэлбээн дээрээс арагш дараход аарцагны гүнд өвдөлт ихсэх /Ларрей/ шинж илэрнэ.

2.3.6 Дунд чөмөгний хугарал.

Шалтгаан.

- Дунд чөмөг нь хүний биеийн хамгийн том чөмөгт яс бөгөөд дээд булуу нь түнхний үе, доод булуу нь өвдөгний үеийг бүрдүүлнэ. Ихэвчлэн морьноос унах, авто осол,шууд цохиулах даруулах зэргээс үүднэ.

Хэлбэр.

- Дээд булуу чөмөгт хэсэгт,доод булуу
- Чөмөгт хэсэг нь дээд, дунд, доод хэсэг гэсэн хэлбэртэй.
- Дээд булууны хугарал ихэвчлэн настай хүмүүст тохиолдоно
- Дээд булууны хүзүүний хугарал нь настай архаг хууч өвчтэй,хэвтэрийн хүмүүст эмгэг байдлаар хугарч хожуу оношлогдох нь элбэг байдаг.

Шинж тэмдэг.

- Энэ үед хөлийн тавхай гадагш эргэсэн,тэр талын хөл үл ялиг богиносолтой,цаа гуяа руу дамжиж өвдөнө гэсэн зовиуртай өсгий наалдах шинж илрэнэ.
- Чөмөгт хэсэг,доод булууны хугарал идэр залуу насны хүмүүст ихэвчлэн тохиолдоно.
- Хугарлаархавантай,эмзэглэлтэй,эмгэг хөдөлгөөнтэй,хугарлын үзүүрүүд тэмтрэгдэнэ. Мөчний чиг,хэлбэр дүрс өөрчлөгдөж, мөч богинооч, тэнхлэгээрээ гадагш буюу дотогш эргэсэн, үйл ажиллагаа алдагдсан байна.
- Хүүхдийн дунд чөмөгний хугарлын үед нойтон бургасны шинж илрэнэ.

Хүндрэл.

- Дунд чөмөгний доод булууны хугаралын үед, хугаралын доод үзүүр арагш дээш зөрж тахимны хонхорын судас мэдрэлийн багцыг дарж гэмтээсэн байж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

2.3.7 Шилбэний ясны хугарал.

Шалтгаан.

- Шилбэний яс нь хүний биеийн гол тулгуур эрхтэн болох шаант, тахилзуур гэсэн хоёр хос яс бөгөөд энэ хугарал нь авто ослын шалтгаантай элбэг тохиолддог. Том чөмөгт ясны хугарлын 70-80 хувийг эзэлдэг. Ихэвчлэн шаант чөмөг доод 3/1 ээр, тахилзуур яс дээд 3/1-ээр хугардаг, бороололт удааширч, хуурамч үе үүссэнээс зөрж бороолон хөлийн тулгуур алдагдаж эдгэх нь олонтой тохиолддог.

Хэлбэр.

- Шилбэний ясны дээд булуу, чөмөгт хэсэг, шагайн үений хугарал, мултрап, чөмөгт хэсгийн хугаралыг дээд, дунд, доод түвшинд, хавсарсан ба дагнасан гэсэн хэлбэртэй.
- Шаант чөмөг нь урьд хянган хэсгээрээ зөөлөн эд байхгүй шууд яс арьс барьцалдаж байдаг учир ил хугарал болох нь олонтой.

Шинж тэмдэг.

- Хугарлыг оношлоход хөлийн тулгуур алдагдсан, хэлбэр дүрс өөрчлөгдсөн, хугарлын үзүүр тэмтрэгдэж, хавирагдах чимээ мэдрэгддэг. Хугарлын дээд үзүүр урагш доош зөрдөг учир хонхойж тэмтрэгдэж, мөч богиноч гадагш эргэж, эмгэг хөдөлгөөнтэй болсон байна. Шаант чөмөгний дээд булууны хугаралын үед өвдөгний үеэр гадагш буюу дотогш муруйлт үүснэ. Энэ хугаралын үед өвдөгний үений холбоос гэмтэх нь олонтой.

2.3.8 Шагайн үений хугарал мултрап.

Шалтгаан: Шагайн үе нь хүний биеийн хамгийн олон яс, үе, холбоосноос тогтдог хөдөлгөөнт, тулгуур эрхтний төгсгөлийн хэсэг учир хугарал, мултрап нь олонтой тохиолдоно. Шагайн үеэр хөмрөх буюу сөхөх байрлалд дотогшоо юмуу гадагш эвгүй гишгэнээс, эсвэл өндөрөөс унах хөшигдэж дарагдах үед гэмтэнэ.

Хэлбэр.

- Гадна хавчаарын хугарал,
- Дотор хавчаарын хугарал,
- Дотно гадна хавчаар яснуудын хугарал,
- Дотно хавчаар үений түвшинд, тахилзуур яс доод 3/1-ээр хугарч, ацан холбоос тасарч шагайн үеэр гадагшаа юмуу дотогш мултрах,/Дюпитериний хугарал мултрап/

Шинж тэмдэг.

- Шагайн үеэр хаван хавдартай эмзэглэлтэй, гишгэж явж чадахгүй, хөхөрч цус хурсан шагайн үений хэлбэр алдагдаж, хавчаар яс доош буусан, хугаралын завсар онойтож тэмтрэгдэнэ, үений хөдөлгөөн хязгаарлагдсан байна.

2.4 Оношилгооны шалгуур.

Зовиур.

- Өвдөлт /байрлал,тархалт,ямар байрлалд өвдөлт ихэсч байгааг илрүүлэх/
- Үйл ажиллагааны алдагдал/гишгэж явж байгаа эсэх,нугалах тэнийлгэх,тулхэх татах,эргүүлэх хөдөлгөөн хийж байгаа эсэх/
- Өвчтний байрлал/хэвтээ,суугаа,босоо/

Өгүүлэмж.

- Хаана, хэзээ,хэдийд ямар байрлалд гэмтэл авсан,гэмтэл учруулсан гадны хүчний хурд, хүч, тухайн орчны байдал, гэмтэл авсан даруйдаа ухаан санаа ямар байсан,тухайн тохиолдолд үзүүлсэн анхны тусlamж орчны нөлөөлөл өөртөө болон бусдаас авсан тусlamж.

Бодит үзлэг.

- Гаднаас нь харж ажиглана./хаван хавдар,шарх,цус алдалт,мөчний чиг,байрлал,хос эрхтнийг хооронд нь харьцуулж ажиглана/
- мөчний чиг
- мөчдийн хэлбэр алдагдсан
- ясны хавиралдах чимээ мэдрэгдэнэ
- хугарлын үзүүр тэмтрэгдэнэ
- эмгэг хөдөлгөөн
- мөчний богиносолт
- үйл ажиллагааны алдагдал

2.5 Лаборатори ба рентген шинжилгээ.

- Атгаал ясны хугарал:Атгаал ясны эгц болон хажуу байрлалын рентген шинжилгээ хийнэ.
- Шуу ясны хугарал:Шуу ясны эгц болон хажуу байрлалын рентген шинжилгээ хийнэ.
- Шууны хугарамтгай хэсгийн хугарал: Шуу ясны эгц болон хажуу байрлалын рентген шинжилгээ хийнэ.
- Сарвуу ясны хугарал: Сарвуу ясны эгц болон хажуу байрлалын рентген шинжилгээ хийнэ.
- Аарцагны хугарал: Аарцагны эгц байрлалын рентген шинжилгээ хийнэ. Шаардлагатай тохиолдолд аарцагны КТГ шинжилгээ хийнэ.
- Дунд чөмөгний хугарал: Дунд чөмөгний эгц болон хажуу байрлалын рентген шинжилгээ хийнэ.
- Дунд чөмөгний гандан /дунд/ хэсгийн хугарал: Дунд чөмөгний эгц болон хажуу байрлалын рентген шинжилгээ хийнэ.
- Дунд чөмөгний доогуурхи хугарал: Дунд чөмөгний эгц болон хажуу байрлалын рентген шинжилгээ хийнэ.
- Шилбэний ясны хугарал: Шилбэний ясны эгц болон хажуу байрлалын рентген шинжилгээ хийнэ.
- Шагайн үений хугарал мултрап: Тавхайн эгц болон хажуу байрлалын рентген шинжилгээ хийнэ.
- Ясны хугарлын үед яаралтай тусlamж үзүүлэхэд асуумж, бодит үзлэгээр хугарлыг оношлон дараагийн шатны эмнэлгийн байгууллагад хүргэнэ.

БҮЛЭГ 3. ЯСНЫ ХУГАРЛЫН ЭМЧИЛГЭЭ

1.1 Эмчилгээний зорилго, зорилт.

3.1.1 Зорилго.

- Өвдөлт намдаах, ясны хугарлын зөрөөг арилгах бэхлэх, мөчдийн үйл ажиллагааг сэргээх.

3.1.2 Зорилт.

- Ясны хугарлын үед үзүүлэх эмчилгээ нь өвдөлт намдаах, цус тогтоох, шархны анхдагч цэгцлэлт хийх, амьдралын чухал эрхтэний үйл ажиллагааг тогтворжуулах, зориулалтын болон гарын доорх чиг ашиглан дараагийн шатны эмнэлгийн байгууллагад хүргэх бөгөөд ясны хугарлаас үүдэн гарах сөрөг үр дүн, хүндэрлээс сэргийлэхэд оршино.

3.2 Эмийн эмчилгээ.

- **Өвдөлт намдаах:** Кеторол 30мг/1мл судсаар, Трамадол 100мг/50 мл судсаар, Морфин 1%-1мл судсаар, Диазепам 5мг/мл, 10мг/2мл судсаар, Гэмтлийн шок болон цус алдалтын үед: Натри хлорид 09% 500-1000мл дуслаар, Декстран 5%-500мл дуслаар,
- **Шарх цэгцлэх:** Арьс зөөлөн эдэд үүссэн шархыг спирт болон иодын уусмалаар ариутган, даралтат болон битүү боолт хийнэ.

3.3 Эмийн бус эмчилгээ.

3.3.1 Чиг тавих заалт: Ясны ил хугарлын үед цус тогтоолт, шарх цэгцлэх, цэвэр боолт хийсний дараа чиг тавина. Чөмөгт ясны гандан хэсгийн хугарлын үед 2 үеийг, үе дайрсан хугарлын үед 3 үе дамнуулан чиг тавина.

3.3.2 Тээврийн чиг тавих заалт: Яс, үе, судас, мэдрэл, зөөлөн эд гэмтсэн үед хэрэглэнэ, тусгай зориулалтын крамер, дитерхсийн чиг ашиглана. Тусгай зориулалтын чиг байхгүй бол гарын доорхи материал ашиглаж /фанер, банз, саваа мод, цанын мод гэх мэт/ чиг хийж болно.

3.3.4 Чиг тавих заавар.

3.3.4.1 Найдвартай бэхэлгээ хийсэн байх: Гэмтсэн эрхтэн буюу хугарлын хэсгийг хөдөлгөөнгүй байлгахад анхаарна. Бэхэлгээ боолтыг хэтэрхий чанга хийвэл тухайн эрхтний цус хангамжинд муугаар нөлөөлнө.

3.3.4.2 Үе дамнуулан бэхэлнэ. Дунд чөмөгний хугарлын үед түнх, өвдөг, шагайн үеэр дамнуулан бэхэлнэ. Тухайлбал, хугарсан буюу гэмтсэн хэсгээс доош буюу дээш нэгээс хоёр үеийг хамруулан чиг боолт тавих нь гэмтсэн ба хугарсан хэсгээр хөдөлгөөнгүй байх нөхцлийг бүрдүүлж өгнө. Чиг тавих материалыа хөвөн, марль, бусад зөөлөн эдээр бүрэх нь зөөлөн эд холгох, дарагдахаас хамгаалах ач холбогдолтой. Ясны төвгөртэй хэсэгт хөвөн, самбайн жийрэг хийж өгөх хэрэгтэй, шууд арьсан дээр тавихгүй.

- 3.3.4.3 Чигийг бэхлэхдээ гэмтсэн мөчийг физиологийн дундаж байрлалд байрлуулна. Том үеэр 10-15 градус нугалан, хугарсан үений хэсэгт ивүүр зөвлөвч, тавьж боолт хийнэ. Хугарсан мөчинд чиг боолтыг хийхдээ өөриин тэнхлэгийн дагуу бага зэрэг таталт хийж, чиг дээр байрлуулна.
- 3.3.4.4 Ясны ил хугарлын үед ясны хэлтэрхийг буцааж хийх, татаж авч болохгүй.
- 3.3.4.5 Ясны ил хугарлын үед шарханд цус тогтоох боолт хийх ба цус их алдаж байвал л чангалаур тавьж чиг тавина. Чангалаурыг 1-1.5 цаг тавих ба цаг хугацааг бичиж хавсаргана.
- 3.3.4.6 Өвчтөний хувцсыг тайлах шаардлагатай бол эрүүл гар, хөлөөс эхэлж тайлна. Хувцас өмсгөхдөө гэмтсэн мөчдөөс эхэлж өмсгөнө. Хувцас тайлах, өмсгөх үедээ өвчтөнийг өндийлгэх, суулгаж болохгүй.
- 3.3.4.7 Өвчтөнийг дамнуурга дээр хэвтүүлэх, босгохдоо гэмтсэн мөчийг барьж зөөнө.
- 3.3.4.8 Өвчтөнийг байрлуулахад дахин гэмтэл ба өвдөлт учруулахгүй, болгоомжтой хандах хэрэгтэй.
- 3.3.4.9 Атгаалын хугаралтай өвчтөнд юуны өмнө өвдөлт намдаах эм өгч, гарын доорхи материалаар хөдөлгөөнгүй чиг тавина. Мөн гурвалжин хэлбэрийн алчуур ашиглаж сойлт, боолт хийж болно.
- 3.3.4.10 Атгаал, шуу, сарвууны гэмтлийн үед анхны тусlamжийг өвдөлт намдаах эм хэрэглэх, хөдөлгөөнгүй болгох чиг тавих /фанер, хавтгай мод ашиглах, гурвалжин алчуур ашиглан сойлт хийх, шархтай бол цэвэр боолт хийх хэрэгтэй.
- 3.3.4.11 Аарцагны хугаралын үед: Юуны өмнө зөв байрлуулах нь чухал бөгөөд ихэвчлэн мэлхий байрлал зохимжтой байдаг. Аарцаг, гуяны булчингуудыг суллаж, хөлийг өвдөг, түнхээр нугалж, бага зэрэг алцгар байрлалд хэвтүүлнэ Үүний тулд гудас, хөнжил зэргийг хуйлж, тахиман доогуур нь ивж байрлуулна. Өвдөлт намдаах, цус тогтоох арга хэмжээ авч, дараагийн шатны эмнэлэгт хүргэнэ.
- 3.3.4.12 Тээвэрлэлт чигийг дунд чөмөгний дээд 1/3-ээс хөлийн хурууны үзүүр хүртэл тавина. Гарын доорхи материал ашиглан, тээврийн чиг тавих ба даавуу, хөвөн гэх мэтээр ороож тавьбал зөөлөн эд холгох, дарагдах нь бага байдгийг анхаар.
- 3.3.4.13 Шилбэний гэмтлийн үед анхны тусlamжийг үзүүлэхдээ цус алдаж байвал чангалаур тавих боолт хийж чиг тавин ойрын эмнэлэгт яаралтай хүргэнэ.
- 3.3.4.14 Өвдөгний үений мениск буюу мөгөөрсөн жийрэг гэмтсэн үед хүчтэй өвдөх ба хөдөлгөөн хязгаарлаж, өвдөгний үеэр боох ба чиг тавьж эмнэлэгт хүргэнэ.
- 3.3.4.15 Хэрвээ цус алдалт байвал чангалаур тавьж, цэвэр боолт хийж, чиг тавина.
- 3.3.4.16 Чиг тавихдаа 2 үеийг дамнуулан (өвдөгний үеэр тэнийлгэх ба тавхай 90 градус байна) тавына. Гэмтсэн мөчдөд гарын доорх материал банс, самбар, хавтгай төмөр гэх мэт ашиглан чиг тавина.

3.3.4.17 Зөөлөн эдийн няцралтын үед өвдөлт намдаах зорилгоор гэмтсэн хэсэгт хүйтэн жин /мөс, хүйтэн ус/ тавих, шалбарч урагдсан хэсгийг савантай усаар угааж, цэвэр даавуугаар боно.

3.3.4.18 Өөрсдөө хугарал болон хугарал мултралыг эвлүүлэх буюу засч болохгүй. Өвчтөнийг яаралтай эмнэлгийн байгууллагад хүргэх хэрэгтэй.

3.3.5 Зөөлөн боолт:

3.3.5.2 Шилбэний ясны хугарлыг: Шагай, шилбэний үе, өвдөг орчим хөвөн, даавуу цаваг хийж 2 ширхэг нарийн банзаар гадна, дотно талд нь бэхлэн, 2 үе оролцуулан боно. Шагайн яс ба тавхайн ясны хугаралтай үед «утсан» чиг хэрэглэнэ.

3.3.5.3 Шилбэний дунд 1/3 хэсгээс хуруудын үзүүр хүртэл утсан чигээ хэлбэржүүлэн хөвөн, самбайгаар цаваг хийж бэхлэн боно. Гарын доорхи материал болон наймын тоо хэлбэрийн боолт ашиглан шагай тавхайн хугаралд бэхэлгээ хийж болно.

3.3.5.4 Эгэмний хугарлын үед: Ихэвчлэн наймын тоо ба цагираг хэлбэрийн боолтыг хэрэглэнэ.

3.3.5.5 Атгаалын хугарлын үед: Гэмтсэн мөчийг их биед шахах маягтай тохойн үеэр 90 градус нугалан, их биетэй хамт бинтэн боолтоор боно /Дезо/.

3.3.5.6 Түрүү маягийн боолтыг: мөр, түнх гэх мэт том үений гэмтлийн үед хэрэглэнэ. Боолтыг зүүнээс баруун тал руу, ташуу, арагш, урагш гэсэн дарааллаар атгаал, дунд чөмгийг тойруулсан маягтай бэхэлж боно.

3.3.5.7 Наймын тоон боолтыг: - шагай, шилбэ, мөр, бугуйн үе, цавь орчим хийнэ.


3.3.5.8 Яст мэлхий хэлбэрийн боолтыг: өвдөг, тохойн үений дунд хэсэгт 2-3 давхар боож, дараа нь үений дээр, доор солбиж хийнэ.

3.3.5.9 Сүүлийн үед зориулалтын яс, үе мөчний гэмтэлийн үед тавьж тээвэрлэх хөнгөн авсаархан, хэрэглэхэд өвчтөнд хүндрэл багатай төрөл бүрийн чигийг өргөн хэрэглэж байна.

3.4 Тээвэрлэлт: Өвчтөний биеийн байдал, хугарлын хэлбэрээс хамааран зөв байрлалыг сонгох хэрэгтэй. Мөчдийн гэмтлийн үед тавигдах стандартын нэг удаагийн чигээс гадна уламжлалт чигийг зөв сонгож ашиглах гарах хүндрэлээс сэргийлэх.

3.5 Хяналт үнэлгээ: Ясны хугарлын үед үзүүлсэн эмнэлгийн яаралтай тусламжийн арга хэмжээ, тээвэрлэлт, мөчдийн үйл ажиллагааны сэргэлт, ясны хугарлын дараагийн шатны эмчилгээний үр дүн, хөдөлмөрийн чадвар алдалт.

ЯСНЫХУГАРАЛ - ЭМНЭЛЭГТ ХҮРТЭЛХ ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН АЛГОРИТМ



НОМ ЗҮЙ

1. С.Г.Гришин "Клинические лекции по неотложной травматологии" 2009
2. А.Эрдэнэбилэг,О.Батсүх,Л.Наранбат,П.Эрдэнэсан "Гэмтэл согог судлал" 2017 он
3. Л.Ганболд "Гэмтэгсдийг Аврах Лавшуулсан Тусламж" гарын авлага 2015 он
4. В.Ф.Трубников "Травматология и Ортопедия" 1986
5. Н.В.Корнилов "Травматология и Ортопедия" 2004
6. U.HEIM "Traumatologue" 2006
7. М.Скалетта "Неотложная травматология" 2006
8. Р.Р.Симон "Неотложная ортопедия конечностей" 1998
9. В.В.Ключевский "Хирургия повреждения" 1999
10. ΘΟΥΑ – 10 (ICD – 10) 2009
11. YOYA – 9 (ICD – 9 - CM) 2008
12. M.O'Connor "Instructional course lecture /AAOS/ Vol.2010-2015"
13. Монгол улсын осол гэмтэл, гадны шалтгаант өвчлөл, нас баралт, тайлан, 2017
14. И.А.Мовшович "Оперативная ортопедия" 1983
15. "Emergency medicine journal" 2015/2016
16. "AO classification" 2008
17. H.Chen "Manual of common bedside surgical procedure" 1996
18. С.Отгонгэрэл "Осол гэмтэлд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж" 1996
19. М.А.Морозов "Первая медцинская помощь при травмах" 1999
20. <https://Ambulance-Russia.blogspot.com>
21. <https://Disease.medelement.com>
22. И.М.Матишин "Симптомы и синдромы в хирургии"
23. Decown "Diagnostic examination" 1979